



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СЭА-2026/004/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2026 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:Batmunkhb@audit.gov.mn">Batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:Otgonbayarts@audit.gov.mn">Otgonbayarts@audit.gov.mn</a> Аудитор: Э.Энхбүрэн Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:Enkhburene@audit.gov.mn">Enkhburene@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ЦАГААННУУР СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Г.ЦЭНДСҮРЭН ТАНАА

2026-03-23 № СЭА-2026/004/НА-СТА-ТТЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Цагааннуур сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар болон санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын хүрээнд илэрсэн дараах зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1, ТБОНӨХБАУХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 31 дугаар зүйлийн 31.1, Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөөт

өртгийн дээд хязгаар"-ын 1, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Орон нутгийн орлогын төлөвлөгөөг **32,455.9** мянган төгрөгөөр тасалсан,
- Харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас зайлсхийж гэрээ шууд байгуулах аргын босго үнэд багтаах зорилгоор **76,000.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий зураг төсвийн ажлыг сумын төвийн явган хүн зам, дугуйн зам, хатуу хучилттай зам зэрэг зураг төсвийн 4 төсөл, арга хэмжээ болгон төлөвлөж, хэрэгжүүлсэн,
- Цагааннуур тохижилт ОНӨААТҮГ нь тайлант онд **30,000.0** мянган төгрөгийн шатахууны худалдан авалтыг тендер зарлалгүйгээр шууд гэрээ байгуулсан,
- Сумын ЗДТГ нь ээлжийн амралттай албан хаагчдад **571.1** мянган төгрөгийн цалинг давхардуулан олгосон, шуудан, холбоо, интернэтийн зардлаас тээвэр, шатахууны зардалд **1,709.0** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна.

#### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд хандиваар 5,774.5 мянган төгрөгийн мотоцикл, зөөврийн компьютер, БОАЖГ-аас 6,800.0 мянган төгрөгийн мотоцикл, аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 557,425.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын техник хэрэгсэл, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 277,733.0 мянган төгрөгийн барилга байгууламж, 85,020 мянган төгрөгийн автомашин, тоног төхөөрөмж, 276,410.1 мянган төгрөгийн гэрэлтүүлэг, дагалдах хэрэгсэл зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэсэн байна.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Улсын төсвийн 5.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар сэргээгдэх эрчим хүчний 2.5 мегаватт чадалтай батареит станцыг ашиглалтанд хүлээн авч эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болсон байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Цагааннуур сумын Засаг дарга нь тайлант онд 3 бүлэг 13 зорилт, 116 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, **76.9** хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	973,557.7	1,288,677.4
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	665,619.7	619,283.4
33	<b>АВЛАГА</b>	160,808.5	253,433.1
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	147,129.5	415,960.8
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	10,637,773.8	11,245,678.2
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	10,637,773.8	11,245,678.2
39200	<b>Биет хөрөнгө</b>	10,519,581.3	10,981,793.8
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	118,192.5	263,884.5
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>11,611,331.5</b>	<b>12,534,355.6</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	5,378.7	52,096.1
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,378.7	52,096.1
41300	Өглөг	5,378.7	52,096.1
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	11,605,952.8	12,482,259.5
51	Засгийн газрын хувь оролцоо	11,605,952.8	12,482,259.5
51100	<b>Засгийн газрын оруулсан капитал</b>	1,588,489.7	1,588,489.7
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	9,298,935.5	10,175,242.2
51300	<b>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</b>	718,527.7	718,527.7
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>11,611,331.5</b>	<b>12,534,355.6</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>4,682,169.5</b>	<b>5,801,798.5</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,587,399.8</b>	<b>1,719,647.4</b>
110	Орлогын албан татвар	1,116,005.1	1,071,897.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,154,162.5	1,128,857.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(38,157.4)	(56,960.9)
113	Хөрөнгийн албан татвар	242,870.7	434,238.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	228,524.0	213,511.6
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,704,994.6</b>	<b>4,082,151.0</b>
122	Тусламжийн орлого	-	1,072,677.9
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,389,775.1</b>	-
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,166,496.8</b>	<b>3,947,150.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,166,496.8</b>	<b>3,947,150.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,088,411.9</b>	<b>3,818,316.0</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,140,570.1	1,392,586.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,882.8	174,320.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	492,553.3	574,009.8
2104	Хангамж, бараа материалын зардал	66,794.5	106,417.9
2105	Нормативт зардал	2,458.8	7,236.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	174,077.3	146,306.2
2107	Томилолт, зочны зардал	15,550.0	15,900.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	129,542.1	249,442.6

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	924,983.1	1,152,096.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>78,084.9</b>	<b>128,834.0</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,515,672.7</b>	<b>1,854,648.5</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,074,590.2</b>	<b>978,341.8</b>
<b>VII</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>(1,074,590.2)</b>	<b>(978,341.8)</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>441,082.5</b>	<b>876,306.7</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,588,489.7	718,527.7	8,850,723.3	11,157,740.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	7,129.7	7,129.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,588,489.7	718,527.7	8,857,853.0	11,164,870.3
4	Тайлант үеийн үр дүн	-	-	441,082.5	441,082.5
5	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,588,489.7	718,527.7	9,298,935.5	11,605,952.8
6	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,588,489.7	718,527.7	9,298,935.5	11,605,952.8
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,588,489.7	718,527.7	9,298,935.5	11,605,952.8
8	Тайлант үеийн үр дүн	-	-	876,306.7	876,306.7
9	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,588,489.7	718,527.7	10,175,242.2	12,482,259.5

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>3,202,116.2</b>	<b>3,938,502.6</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,587,399.8</b>	<b>1,719,647.4</b>
110	Орлогын албан татвар	1,116,005.1	1,071,897.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(38,157.4)	(56,960.9)
113	Хөрөнгийн албан татвар	242,870.7	434,238.8
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>228,524.0</b>	<b>213,511.6</b>
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,937.4	14,084.1
1181	Газрын төлбөр	120,065.4	90,166.8
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	98,521.2	109,260.7
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>224,941.3</b>	<b>2,218,855.2</b>

120	Нийтлэг татварын бус орлого	224,941.3	327,977.1
122	Тусламжийн орлого	-	1,072,677.9
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	818,200.2
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,389,775.1</b>	<b>-</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,350,565.7</b>	<b>2,792,357.4</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,350,565.7</b>	<b>2,792,357.4</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,272,480.8</b>	<b>2,663,523.4</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,182,716.6	1,478,828.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	147,513.1	174,320.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	514,723.9	597,747.8
2104	Хангамж, бараа материалын зардал	84,193.1	124,342.8
2105	Нормативт зардал	2,458.8	7,236.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	107,274.3	41,257.6
2107	Томилолт, зочны зардал	15,550.0	15,900.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	42,696.7	89,615.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	175,354.3	134,274.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>78,084.9</b>	<b>128,834.0</b>
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>851,550.5</b>	<b>1,146,145.2</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,255,729.9</b>	<b>1,067,481.5</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,255,729.9	1,067,481.5
2200	Дотоод эх үүсвэрээр	1,255,729.9	1,067,481.5
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>(1,255,729.9)</b>	<b>(1,067,481.5)</b>
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	125,000.0
<b>VII</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-</b>	<b>(125,000.0)</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(404,179.4)</b>	<b>(46,336.3)</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,069,799.1	665,619.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	665,619.7	619,283.4

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>4,680,309.8</b>	<b>3,724,511.0</b>	<b>955,798.8</b>	<b>79.6%</b>
<b>11</b>	<b>Татварын орлого</b>	<b>1,711,679.7</b>	<b>1,719,647.4</b>	<b>(7,967.7)</b>	<b>100.5%</b>
110	Орлогын албан татвар	1,114,525.6	1,071,897.1	42,628.5	96.2%
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,171,486.5	1,128,857.9	42,628.6	96.4%

1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(56,960.9)	(56,960.9)	(0.0)	100.0%
113	Хөрөнгийн албан татвар	379,272.5	434,238.8	(54,966.3)	114.5%
118	Бусад татвар, төлбөр, хураамж	217,881.6	213,511.6	4,370.0	98.0%
<b>12</b>	<b>Татварын бус орлого</b>	<b>5,608,445.8</b>	<b>4,836,196.4</b>	<b>772,249.4</b>	<b>86.2%</b>
120	Нийтлэг татварын бус орлого	277,638.4	172,060.1	105,578.3	62.0%
122	Тусламжийн орлого	2,690,991.7	1,832,803.5	858,188.2	68.1%
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	<b>818,200.2</b>	<b>818,200.2</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,680,309.8</b>	<b>3,724,511.0</b>	<b>955,798.8</b>	<b>79.6%</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,759,611.4</b>	<b>2,541,947.0</b>	<b>217,664.4</b>	<b>92.1%</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,658,814.1</b>	<b>2,456,854.3</b>	<b>201,959.8</b>	<b>92.4%</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,459,771.1	1,391,906.3	67,864.8	95.4%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	182,440.7	174,235.0	8,205.7	95.5%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	576,720.8	574,009.8	2,711.0	99.5%
2104	Хангамж, бараа материалын зардал	73,804.1	47,988.3	25,815.8	65.0%
2105	Нормативт зардал	3,924.8	739.7	3,185.1	18.8%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	81,881.5	47,862.1	34,019.4	58.5%
2107	Томилолт, зочны зардал	26,575.3	14,660.0	11,915.3	55.2%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114,093.0	75,401.3	38,691.7	66.1%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	139,602.8	130,051.8	9,551.0	93.2%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>100,797.3</b>	<b>85,092.7</b>	<b>15,704.6</b>	<b>84.4%</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,790,698.4</b>	<b>1,057,563.9</b>	<b>733,134.5</b>	<b>59.1%</b>
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>130,000.0</b>	<b>125,000.0</b>	<b>5,000.0</b>	<b>96.2%</b>
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>662,155.3</b>	<b>(662,155.3)</b>	
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>616,668.9</b>	<b>(616,668.9)</b>	
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>77.0</b>	<b>77.0</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>3.0</b>	<b>3.0</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
610001	Төсвийн байгууллага	3.0	3.0	-	100.0%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>37.0</b>	<b>37.0</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
620001	Удирдах ажилтан	8.0	8.0	-	100.0%

620002	Гүйцэтгэх ажилтан	18.0	18.0	-	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	3.0	3.0	-	100.0%
620004	Гэрээт ажилтан	8.0	8.0	-	100.0%
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>37.0</b>	<b>37.0</b>	<b>-</b>	<b>100.0%</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.0	11.0	-	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12.0	12.0	-	100.0%
650010	Гэрээт ажилтан	8.0	8.0	-	100.0%
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.0	6.0	-	100.0%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
<b>1</b>	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>60,852.6</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>60,852.6</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>60,852.6</b>
<b>1221</b>	<b>Хандив тусламж /дотоод/</b>	<b>60,852.6</b>
<b>12213</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>60,852.6</b>
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	52,098.7
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,394.8
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,359.1
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>59,819.7</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>59,819.7</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>59,819.7</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	679.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85.0
2104	Хангамж, бараа материалын зардал	45,731.9
2105	Нормативт зардал	6,496.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	913.2
2107	Томилолт, зочны зардал	1,240.0
2108	Бүсдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,223.0
<b>4</b>	<b>ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>1,032.9</b>
<b>5</b>	<b>АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(1,032.9)</b>
<b>6</b>	<b>Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(1,032.9)</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт **28,873.3** мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залруулсан.

#### Залруулсан алдаа:

- ЗДТГ: Хөрөнгийн элэгдлийг 27,000.0 мянган төгрөгөөр илүү тооцсоноос санхүүгийн үр дүнгийн тайланд зардал илүү тайлагнасан,
- ХХС: Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголтын программд 3 зээлдэгчийн төлөлтийн хуваарийг батлагдсан гэрээний хуваариас зөрүүтэй оруулснаас зээлийн үлдэгдэл 1,873.3 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалт болон УСНББОУС-1 “*Санхүүгийн тайлангийн толилуулга агуулга*”-ийн 27-д “*Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой...*”, санхүүгийн тайлангийн “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт **161,823.9** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс **571.1** мянган төгрөгийн төлбөрийн акт, **34,164.9** мянган төгрөгийн 2 албан шаардлага, **127,087.9** мянган төгрөгийн 7 зөвлөмж өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар нийт **106,000.0** мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс **140,736.0** мянган төгрөгийн залруулагдаагүй материаллаг зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс **101,264.5** мянган төгрөгөөр их тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

1. ЗДТГ нь тайлант онд нийгмийн ажилтан Э.Бадмаанямбууд 501.6 мянган төгрөгийн, 2 дугаар багийн засаг дарга С.Одсүрэнд 69.5 мянган төгрөгийн нийт 571.1 мянган төгрөгийн цалинг ээлжийн амралттай давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ:”, 20.2.5 дахь “... төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 дэх “*Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ ...*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Албан шаардлага

1. ТТЗ нь орон нутгийн орлогын төлөвлөгөөг 32,455.9 мянган төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэх албан шаардлага хүргүүлэв.

2. Сумын ЗДТГ нь шуудан, холбоо, интернэтийн зардлаас тээвэр, шатахууны зардалд 1,709.0 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 20.2.5 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлийг үнэн зөв тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 5.3.1. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлтэй холбоотой:

1.1. Илрүүлэлт: ХХС-аас нь 2019-2021 онуудад олгосон 8 зээл буюу нийт зээлийн үлдэгдлийн 24% буюу 60,209.6 мянган төгрөгийн чанаргүй зээлийн авлага үүссэн байхад холбогдох байгууллагад шилжүүлэх замаар барагдуулах арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 7.1 дэх Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагааны үр дүнг дараах зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр үнэлнэ: 2 “Чанаргүй зээлийн хэмжээ-Нийт хөрөнгийн 10 хувиас бага байх”, 10.5 дахь “Зээлдэгчийн гэрээнд эрсдэл үүссэн тохиолдолд зээлийн хөрөнгийг эргүүлэн татах ажиллагааг сумын Засаг дарга болон хяналтын зөвлөл хариуцан зохион байгуулна. Энэхүү зохицуулалтыг зээлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна” гэсэн заалтуудыг тус

тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Чанаргүй зээлийн үлдэгдлийг бууруулах шат дараалсан арга хэмжээг авч ажиллах.

2.1. Илрүүлэлт: ХХС нь хугацаа хэтэрсэн зээлийн 7,103.7 мянган төгрөгийн алдангийг дутуу тооцоолж бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Хугацаа хэтэрсэн зээлийн алдангийг дахин тооцоолж бүртгэх.

### **5.3.2. Хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой:**

1.1. Илрүүлэлт: Ойн анги нь ногоон сэргэлтийн бодлогын хүрээнд ойн түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулах төслөөр Ойн газраас нийт 35,910.3 мянган төгрөгийн ой хээрийн түймрийг унтраах багаж, хамгаалах хувцас хэрэглэлийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан боловч бүртгэл тайланд тусгаагүй, жилийн эцэст уг хөрөнгийг тоолж баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь *“Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ:”*, 12.2.1 дэх *“жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө”*, 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”*, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь *“бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”*, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Иж бүрэн байх”* батламж мэдэгдлийг хангаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн хөдөлгөөн бүрийг бүртгэл тайланд тусгаж, хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

2.1. Илрүүлэлт: Ойн анги нь үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн нийт 12 нэр төрлийн 9,549.3 мянган төгрөгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох болон актлах саналыг холбогдох газарт хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь *“илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”*, УСНББОУС-17 *“Үндсэн хөрөнгө”*-ийн ХЗУ 4-д *“... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх хэрэгтэй*

...” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглаж байгаа хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон актлах эсэх саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

3.1. Илрүүлэлт: Ойн анги нь Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар өөрийн хөрөнгөд бүртгэлгүй фургон автомашинд 5,000.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээг хийсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ.*” 14.4.2 дахь “*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага*” гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Иж бүрэн байх*” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн хөдөлгөөн бүрийг бүртгэл тайланд тусгаж, хөрөнгөд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгөв.

### **5.3.3. Цалин хөлстэй холбоотой:**

1.1 Илрүүлэлт: ЗДТГ нь албан хаагчдын цалингаас 9,315.0 мянган төгрөгийн хуримтлалын сангийн мөнгийг суутгаж олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 119 дүгээр зүйлийн “*Цалин хөлснөөс хийх суутгал, түүний хэмжээг хязгаарлах*”, 119.1.4 дэх “*хууль тогтоомжид заасан бусад тохиолдол*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангаагүй байна

1.2 Өгсөн зөвлөмж: Цаашид албан хаагчдын цалингаас хууль тогтоомжид зааснаас бусад суутгалыг суутгахгүй байх зөвлөмж өгөв.

### **5.3.4. Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбоотой:**

1.1 Илрүүлэлт: Цагааннуур тохижилт ОНӨААТҮГ нь цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрлийг холбогдох байгууллагаас аваагүй, үйлчилгээний үнэ, тарифын хэмжээг Зохицуулах зөвлөлөөр баталгаажуулалгүйгээр үйл ажиллагаа явуулсан.

Энэ нь Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “*хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ*”, 14 дүгээр зүйлийн 14.2.6-д “*үйлчилгээний тарифын хэмжээ тогтоох саналыг боловсруулж, Зохицуулах хороогоор батлуулж, мөрдөх*” заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангаагүй байна

1.2 Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжид заасан холбогдох зөвшөөрлийг авч үйл ажиллагаандаа мөрдөх зөвлөмж өгөв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ЗДТГ	1	27,000.0			1	27,000.0	1	27,000.0				
ХХС	1	1,873.3			1	1,873.3	1	1,873.3				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>28,873.3</b>			<b>2</b>	<b>28,873.3</b>	<b>2</b>	<b>28,873.3</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ТТЗ	1	32,455.9			1	32,455.9						
ЗДТГ	3	11,595.1	1	571.1	1	1,709.0	1	9,315.0				
Цагааннуур тохижилт ОНӨААТҮГ	1	-					1	-				
ХХС	2	67,313.3					2	67,313.3				
Ойн анги	3	50,459.6					3	50,459.6				
<b>ТТЗ-ийн Дүн</b>	<b>10</b>	<b>161,823.9</b>	<b>1</b>	<b>571.1</b>	<b>2</b>	<b>34,164.9</b>	<b>7</b>	<b>127,087.9</b>				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Дүн								
<b>ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>								
Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөж, зохион байгуулаагүй	2	106,000.0			2	106,000.0		
Дүн	2	106,000.0			2	106,000.0		
<b>Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>								
Дүн								
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>106,000.0</b>			<b>2</b>	<b>106,000.0</b>		